

“МӨРГӨЛДӨӨН” ХЭМЭЭХ ОЙЛГОЛТЫН ТУХАЙД

Р.Болд
Судлаач

Манайхан славян хэлний “конфликт”, англи-саксоны болон роман хэлний бүлгийн “conflict” гэдэг үгийг зөрчил, зөрөлдөөн, зөрчилдөөн, сөргөлдөөн, мөргөлдөөн гэх мэтээр олон янзаар орчуулдаг. Үгийн гарал зүйн үүднээс авч үзвэл conflict – конфликт нь латин хэлний “conflictus” хэмээх үгнээс гаралтай аж. Харин латины conflo, conflatio, conflictio, conflictus хэмээх үг нь өдөөх, түлхэх, мөргөлдөх гэсэн утгыг илэрхийлнэ. Я.Цэвэл агсны Монгол хэлний товч тайлбар толь бичигт “Мөргөлдөөн — мөргөлдөх үйлийн нэр, тэмцэлдээн” гэж тайлбарласан байдаг.¹

Латины conflictus нь өөрөө мөргөлдөх үйлийн нэр. Иймд түүнийг монгол хэлэнд “мөргөлдөөн” гэж хөрвүүлэх нь хэл зүйн талаасаа илүү үндэслэлтэй юм. Дашрамд тэмдэглэхэд “conflict” хэмээх үг нь эдүгээ хамгийн өргөнөөр хэрэглэгддэг олон улсын нэр томъёо болж хувирсан аж.

Гэвч бидний хувьд энд орчуулах урлагаас илүү уг ойлголтын жинхэнэ утга агуулгыг таньж мэдэх асуудал чухал байна. Мөргөлдөөн гэдэг үг нь монгол хэлэнд олон салаа утгатай, бүдэг балархай ойлголт гэж хэлж болно. Мөргөлдөөн, зөрчилдөөн, сөргөлдөөн, маргалдаан, тэмцэлдээн, дайн байлдаан гэх мэт үг хэллэгийг энгийн яриа хооронд ижил утгаар хэрэглэхэд болохгүй гэх газаргүй, харин тодорхой шинжлэх ухааны онол, арга зүйд бол ингэж адилтгах нь баахан төөрөгдөлд оруулж, судалгаа шинжилгээг будлиантуулах нягууртай.

Аливаа судалгаа шинжилгээний зайлшгүй чухал урьтал нөхцөл бол судалгааныхаа үндсэн ойлголтыг тодорхойлох, тухайн шинжлэх ухааны “араг яс”-ыг бүрдүүлдэг ойлголтын аппаратыг боловсруулах явдал билээ. Ойлголт бол нэг талаас сэтгэхүйн үйлдэл, нөгөө талаас сэтгэхүйгээс үл хамаардаг ойлголтын объект мөн. Сэтгэхүйн хэлбэрийн хувьд ойлголтын шинж тэмдэг нь хувиршгүй тогтмол, оновчтой, түгээмэл байдагт оршино. Иймээс шинжлэх ухааны танин мэдэхүй ойлголтын сэтгэхүйгүйгээр байх боломжгүй юм.

Алив юмс, үзэгдлийг ухаарах ойлголтын тухайд Фридрих Гегель (*Friedrich Hegel*) хэлэхдээ “Ойлголтыг хэлбэр мэт, тэгэхдээ төгсгөлгүй, бүтээлч, аливаа агуулгыг бүхэлд нь өөртөө багтаасан, үүний зэрэгцээ эх булаг болж байдаг хэлбэр мэт үзвэл зохих нь мэдээж билээ... Ойлголт гэгчийг гараар барьж болохгүй, ер ойлголтын тухай өгүүлэхэд бид хараа ба сонсголыг хойш тавибал зохих болой” гэжээ.² Гегель ойлголтыг тодруулсан энэхүү тодорхойлолтоороо түгээмэл, онцгой, нэгж чанарын хоорондох диалектик холбоог гаргасан аж. Ойлголт бол ахуй ба мөн чанарыг өөртөө агуулж байдаг тодорхой юм.

Мөргөлдөөн хэмээх ойлголт нь хүмүүн төрөлхтний туухтэй нас чацуу гэдэгтэй маргах хүн ховор биз ээ. Хүн үүссэн цагаасаа л өөр хоорондоо дайтаж эхэлсэн бололтой (мэдээж сармагчин байхдаа бас зугээр суугаагүй байх). Үүнийг эртний грекийн гун ухаантан Гераклитын (Heraclitus) хэлсэн гэх “Дайн бол бүх юмны эцэг” гэж үг батлах мэт. Томас Гоббс (Thomas Hobbes) нийгмийн ердийн байдлыг “бүгдээрээ бүхний эсрэг” эмх замбараагүй дайн гэж тодорхойлжээ. Аугаа их Гегель хуртэл “хүн угаасаа түрэмгий” амьтан гэх утгатай зүйл бас биччихсэн байна. Ч. Дарвин (Darvin) ч “хүчтэй нь хүчгүйгээ” гэж хэлж байгалийн иалгарлын онол бүтээсэн, тэр нь нийгмийн шинжлэх ухаанд багагүй нөлөөлсөн байдаг.

Дээрх эрхмүүдийн хэлсэн үгээс үзвэл хүн мах цуснаасаа түрэмгийлэх хорхойтой юмсанж. Бодвол энэ муухан чанар нь түүний зооглодог хоол хүнстэй холбоотой байж магадгүй. Мах иддэггүй амьтад дээр хийсэн туршилтаас үзэхэд тэдгээр амьтаст түрэмгийлэх чанар бага байсан гэдэг. Байнга махаар хооллодог арслан, бар, аварга загас мэтийн амьтад маш зэрлэг

1 Цэвэл.Я., Монгол хэлний товч тайлбар толь, УБ. 1966. х. 345

2 Гегель Г. В. Ф., Логикийн шинжлэх ухаан, УБ, 2004. х. 246

түрэмгий байдгийг бид сайн мэднэ. Гэхдээ тэдгээрт сэтгэх чадвар байдаггүй. Харин *homo sapiens* бол оюун ухаантай, сэтгэдэг амьтан бөгөөд тууний сэтгэн бодох чадамж, махчин чанар хоёр нийлэхээрээ хамгийн аймшигтай болж байгаа ам. Өөрөөр хэлбэл, хүн гэдэг чинь аймшигтай амьтан болой. Нйм үндэслэлээр “хүн угаасаа түрэмгий” гэдгийг үгүйсгэх аргагүй.

Ер нь түүхийн шарласан хуудсыг сөхөж үзвэл янз бүрийн дайн байлдаан, том жижиг мөргөлдөөний уригаар хүний нийгэм хагас тэрбум нэгжээ алджээ. Одоо ч гэсэн бөмбөрцгийн хаа нэгтээ идэвхийлэн дайтсаар л байна. XIII – XIV зуунд хамгийн сайн байлддагаараа гайхагдаж байсан хөх толботнууд өнөөдөр мөнөөх л Багдадынхаа ойролцоо оччихсон явж байх. Тэгэхээр тулалдах, мөргөлдөх нь хүмүүний байнга хийдэг ажил бололтой.

Гэвч бид “мөргөлдөөн” гэж ярихдаа чухам юуг хэлээд байна вэ? Ийм нэр томъёог шинжлэх ухааны ном зохиолд ч, өдөр дутмын сонины нийтлэлд ч, ердийн ухамсрын хулээн авах түвшинд ч тэр янз бүрийн утгаар хэрэглэдэг учраас иймэрхүү үгчилсэн асуултыг тавихад буруудахгүй биз ээ.

МӨРГӨЛДӨӨНИЙГ ОЙЛГОХ ТУЛГЫН ГУРВАН ЧУЛУУ

Мөргөлдөөнийг ойлгоход уг үзэгдлийн тулгуур гурван элементийг тодруулах хэрэгтэй болно. Үүнд:

1. Мөргөлдөөнд оролцогчид, түүний нийгмийн орчин нөхцөл
2. Мөргөлдөөний объект
3. Мөргөлдөөний субъектив ойлгоц ба бие хүний элемент.

Мөргөлдөөнийг хэрхэн ойлгосноос хамаарч түүнийг зохицуулахад бид яаж хандах нь хамаарна. Мөргөлдөөн гагцхүү ашиг сонирхол, хүсэл эрмэлзлийн хоорондын тэмцэл биш. Хэрэгцээ, эрх мэдэл, үнэт зүйлс, бие хүний зан авирын хэв шинж, ойлголт, дүйцээгүй үнэлэлт, үнэлэмж болон сэтгэл зүйн дотоод зөрчилдөөн нь бидний харилцааны болоод түүнийг тодруулагч мөргөлдөөний салшгүй хэсэг байдаг. Мөргөлдөөнийг үр нөлөөтэй удирдан чиглүүлэх, зохицуулах, шийдвэрлэх, улмаар урьдчилан сэргийлэхийн тулд тэр нь чухам ямар хэсгүүдээс бүрдэж байгааг ойлгох нь чухал.

1. МӨРГӨЛДӨӨНД ОРОЛЦОГЧИД, ТҮҮНИЙ НИЙГМИЙН ОРЧИН НӨХЦӨЛ

Мөргөлдөөнийг ойлгох нь түүнд оролцогчдыг тодорхойлохоос эхэлнэ. Мөргөлдөөнд оролцогчид нь бие хүн, нийгмийн бүлэг, байгууллага, улс орон, улсуудын эвсэл байж болно.

Мөргөлдөөний үндсэн оролцогчид нь тэмцэлдэгч талууд юм. Өргөн утгаар авч үзвэл мөргөлдөөнд татагдан орсон бүхэн түүний шууд оролцогч болдоггүй. Цаана нь бас өдөөн хатгагч, хамсаатан, зохион байгуулагчид, дэмжигчид, идэвхгүй гэрчүүд, зуучлагчид болон бусад сонирхолтой этгээдүүд байж л байдаг. Өөрөөр хэлбэл, зөвхөн бие биесийнхээ эсрэг идэвхтэй үйлдэл (давших юмуу хориглон хамгаалах) хийж буй субъектыг л сөргөлдөгч тал буюу мөргөлдөөнд шууд оролцогч гэж нэрлэнэ. Тэд мөргөлдөөний ноён нуруу болдог. Мөргөлдөөнд ихэвчлэн сөргөлдөгч хоёр тал оролцдог боловч зарчмын хувьд өөрийн зорилго бүхий гурав болон түүнээс олон тал ч оролцож болно. Мөргөлдөөнөөс гол оролцогч талуудын ядаж нэг нь гарахад л мөргөлдөөн зогсдог явдал бий (эсвэл түүний оролцогчдын бүрэлдэхүүн өөрчлөгдөнө).

Тийнхүү нийгмийн мөргөлдөөний хувьд ямагт наад зах нь харилцан сөрөг үйл ажиллагаа явуулж буй хоёр тал байх шаардлагатай. Тэдгээрийн үйлдлүүд ихэвчлэн харилцан үгүйсгэсэн ашиг сонирхол, зорилгод суурилдагаас талуудыг мөргөлдөөнд хүргэдэг болой.

Сөргөлдөгч талууд янз бүрийн түвшинд хамаарагддаг. Жишээ нь бие хүн өөр бие хүнтэй бус, харин бүлэг юм уу төр засагтай сөргөлдөх гэх мэт. Сөргөлдөгчдийг нилээд ерөнхий байдлаар түвшинчлэн ангилж болно. Үүнд:

1. Нэгдүгээр түвшний сөргөлдөгч – мөргөлдөөнд өөрийн хувийн ашиг сонирхлын үүднээс, өөрийн нэрийн өмнөөс оролцож буй бие хүнийг хэлнэ.
2. Хоёрдугаар түвшний сөргөлдөгч - бүлгийн ашиг сонирхлыг илэрхийлэгч, хамгаалагч хувь хүнийг нэрлэнэ.
3. Гуравдугаар түвшний сөргөлдөгч: бүлэг – бүлэг байдлаар сөргөлдөгчдийг хэлнэ.

4. Дээд түвшний сөргөлдөгч - хуулийн өмнөөс үйл ажиллагаа явуулж буй төр засгийн бүтцийг ойлгоно.

Төр засаг өөрөө өөртэйгөө эн зэрэгцэх этгээдтэй бус, харин олон нийтийн байгууллага, улс төрийн нам, шахалтын бүлэг гэх мэттэй сөргөлдөх нь цөөнгүй байдаг. Тиймэрхүү мөргөлдөөн, хэрэв хуулийн бус хэлбэрээр явагдвал ихэвчлэн маш хурц, ширүүн байх бөгөөд цөөнгүй тохиолдолд сул талынх нь ялагдлаар (үхлээр) төгсдөг. Нийгмийн үүднээс авч үзвэл мөргөлдөөнд оролцогчдын үүрэг нь нийгмийн ач холбогдлоороо, хүчээрээ, нөлөөгөөрөө ихээхэн ялгаатай байдаг нь ялангуяа бие хүн төр засагтай сөргөлдөх үед онцгой хурц илэрдэг. Мэдээж ийм төрлийн мөргөлдөөнд оролцогчдын хүч нэн тэнцвэргүй байдаг болохыг 1960-аад оны эхэн үед Монголд гарсан “намын эсрэг бүлэг” болон Д.Төмөр-Очирын эмгэнэлт хувь заяа гэрчилнэ.

Мөргөлдөөний оролцогч бүр мөргөлдөөн үүсэх явцад өөр өөрийн сэдэл, зорилго, сонирхол, үнэт зүйлс, чиг хандлагыг удирдлага болгодог. Мөргөлдөөний далд үед сөргөлдөгч талуудыг тэр болгон тодорхойлоход бэрхшээлтэй бөгөөд харин мөргөлдөөн ил байдалд шилжихэд оролцогчид тодрон гарч ирдэг. Түүнчлэн оролцогчдын нийгмийн ач холбогдол ч тэр, зорилго зорилт ч тэр мөргөлдөөн өрнөлийнхөө дээд цэгт хүрсэн тохиолдолд л онцгой тодорхой илэрч гардаг аж. Чухам энэ үед л мөргөлдөөний хөгжилд “үнэний агшин” ирж, оролцогчдын хэн нь хэн болох нь тогтоогддог байна.

Мөргөлдөөнд оролцогчдын гүйцэтгэх үүрэг харилцан адилгүй. Гэвч ихэнх мөргөлдөөнд сөргөлдөгч талуудын үндсэн үүрэг нь бүхий л мөргөлдөөний туршид бараг өөрчлөгдөхгүй үлддэг. Тэрчлэн талуудын үүрэг нь зөвхөн дээр дурьдсан зиндаа, түвшинтэй бус нийгмийн хэлхээ холбооны өргөн хүрээ, нийгмийн буюу бүлгийн дэмжлэгийн хэмжээ лүгээ холбоотой байдаг.

Мөргөлөөний микро орчинг бүрдүүлдэг шууд оролцогчдоос гадна мөргөлдөөний үйл явцад чухал, зарим үед шийдвэрлэх үүргийг макро орчин болох тодорхой, түүхэн нийгмийн орчин, нөхцөл мөн гүйцэтгэдэг. Нийгмийн орчин нь мөргөлдөөн үүсэн хөгждөг хөрсийг тодорхойлдог ба энэхүү ойлголтод сөргөлдөж буй талуудын ойрын хүрээ төдийгүй холын илүү өргөн хүрээлэл, тэдний харьяалагддаг нийгмийн томоохон бүлгүүд, тэрчлэн нийгэм бүхэлдээ ордог. Учир иймд нийгмийн аливаа мөргөлдөөний үндэс язгуур, учир шалтгааныг тодруулахын тулд бүхэл бүтэн цогц нөхцөл байдлуудыг, тухайлбал: эдийн засаг, улс төр, үзэл суртал, шашин шүтлэг, үндэстэн угсаатны болон экологи, газар зүйн зэрэг хүчин зүйлүүдийг харгалзан үзэх хэрэгтэй.

Бие хүн, эсхүл бүлгийн түвшинд аливаа үйлдлийн шалтгаан, шинж чанарын тухай асуултанд хариулахын тулд макро түвшинд энэ үйл ажиллагааны нийгмийн холбогдлыг эрж хайх, тайлбарлах шаардлагатай юм. Энд бие хүний мөргөлдөөнт зан үйлийн шалтгаан хийгээд мөргөлдөөний субъектүүдын, түүний дотор нийгмийн бүлгүүдийн хооронд тодорхой холбоо байдаг нь эргэлзээгүй юм шиг байна.

Нийгмийн харилцан үйлчлэлийн чухал үзэгдэл болох бүлэг хоорондын хийгээд бүлгийн доторх мөргөлдөөн бидний амьдралд хангалттай олон тохиолддог нь одоо нэгэнт тодорхой болсон билээ. Зөвхөн бие хүмүүс, хөдөлмөрийн хамт олон, гэр бүл төдийгүй нийгмийн анги, давхраа, төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэний хөдөлгөөн, улс төрийн намууд гэх мэт нийгмийн томоохон бүлгүүд хүртэл өөр хоорондоо мөргөлдөөнт харилцаанд ордог болжээ.

Чухамхүү нийгмийн эдгээр нийтлэгүүд мөргөлдөөний нийгмийн орчинг тодруулдаг. Ямар ч мөргөлдөөн (бие хүмүүсийн хоорондын мөргөлдөөнөөс олон улсын мөргөлдөөн хүртэл) өргөн утгаараа нийгмийн шинжтэй байдаг.

Нийгмийн томоохон нийтлэгүүдийн мөргөлдөөнт харилцааг дагалдан бие хүмүүсийн хооронд хүртэл том жижиг зөрчил, мөргөлдөөн өдий төдий гардаг. Ийм учраас нийгмийн нийтлэг (бүлгийн) шинж байдал нь мөргөлдөөнийг ойлгоход үндсэн үүрэг гүйцэтгэдэг болохыг бүрэн үндэслэлтэйгээр баталж болно. Аливаа нийгмийн бүлгийн үйлдэл эцсийн эцэст тодорхой бие хүмүүсийн үйлдлээр илэрдэг болой.

2. МӨРГӨЛДӨӨНИЙ ОБЪЕКТ

Энэ хорвоогийн бүх юмс, үзэгдэл өөр хоорондоо гинжлэгдсэн мэт шалтгаант чанартай билээ. Бид сөргөлдөгч талуудын сэдлэг шалтгааны үндсийг илрүүлснээр тэдний мөргөлдөөний утга учрыг тодорхой хэмжээгээр ойлгож эхэлнэ. Гэхдээ шалтгаан хэмээх категорийг шалтагтай хольж хутгаж үл болно. *Шалтаг* гэдэг нь алив нэг юмс, үзэгдэл үүсэхэд хүргэж буй түлхэц юм. Жишээлбэл, Дэлхийн нэгдүгээр дайн дэгдээх шалтаг нь Австрийн хан хүүг Сараевод хөнөөсөн явдал болсон. Харин дайн хийх жинхэнэ шалтгаан нь дэлхийг хувааж захирах гэсэн их гүрнүүдийн сонирхол байлаа.

Мөргөлдөөнийг ойлгоход зайлшгүй авч үзэх дараагийн элемент бол түүний объект юм. Аливаа мөргөлдөөн нь өөрийн учир шалтгаантай байдаг ба ямар нэгэн хэрэгцээг хангах, ямарваа зүйлийг эзэмших хүсэл, шаардлагын улмаас үүсдэг. Тэдгээр зүйлсийг мөргөлдөөний объект гэх ба объект нь мөргөлдөөний хөдөлгөгч хүч мөн. Ер нь мөргөлдөөн нь объект, субъект хоёроос хамаарахгүйгээр дангаараа оршиж чаддаггүй.

Мөргөлдөөний объект нь материаллаг хийгээд материаллаг бус үнэт зүйлс, үнэлэмж байдаг. Объектыг туйлын болзмол шинжтэйгээр дараах гурван төрөлд хувааж болно:

1. Хэсэгчлэн хуваах болон хэн нэгэнтэй хамтарч эзэмших боломжгүй объект,
2. Мөргөлдөөнд оролцогчдод янз бүрийн хэмжээгээр хувааж ноогдуулах боломжтой объект,
3. Мөргөлдөөнд оролцогчид хамтран эзэмших боломжтой объект.

Объект нь мөргөлдөөний шалтгаан болдог бөгөөд нийгмийн амьдралын тодорхой хүрээнд илэрч байдаг. Эдийн засгийн хүрээнд жишээлбэл, мөргөлдөөний объект нь цалин, тэтгэвэр, татвар, тариф, өмч хөрөнгө, ашиг орлого, хөдөлмөрийн нөхцөл, хуваарилалтын систем, хүмүүсийг нэгтгэсэн ямарваа нэг тодорхой үйлдвэрлэлийн үйл ажиллагаа гэх мэт байж болно.

Мөргөлдөөний объект сөргөлдөгч талуудын хувьд ерөнхийдөө ижил байдаг. Гэхдээ талууд түүнийг өөр өөрөөр тайлбарлаж болохыг үгүйсгэхгүй. Энэ нь мөргөлдөөний субъектүүдийн тавьж буй өөр хоорондоо ялгаатай байж болох зорилго, зорилгоос шалтгаална. Жишээлбэл, түрэмгийлэгч гүрний хувьд мөргөлдөөний бодит объект нь нөгөө талын улс төрийн дэглэм байж болно. 2002 онд АНУ Иракт довтолсон шалтгаан нь үнэндээ Саддам Хусейны дэглэмийг унагах явдал байсан, түүнээс биш Ж.Бушийн ярьдгаар цөмийн зэвсэг нууцаар үйлдвэрлэхтэй төдийлөн холбоогүй халдлага юм. Манай Монголд ч иймэрхүү өнгөлөн далдалсан объектоор мөргөлдөөн гарах нь бий. Тухайлбал 2006 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр ЧД-ийн Цагдаагийн хэлтсийн дэргэд болсон цагдаагийн ажилтнууд болон иргэний хөдөлгөөнийхний хоорондын хүч хэрэглэсэн мөргөлдөөн нь гадна талдаа ганц ширхэг монгол гэрийн төлөө байсан ч цаанаа өөр зорилготой байв. Энд монгол гэр мөргөлдөөний объект байгаагүй, харин түүгээр дамжуулан мөргөлдөөнийг хурцатгах, улмаар тэмцлийн бодит объект, зорилго болох Засгийн газрыг огцруулах, УИХ-ыг тараах явдал байлаа.

Янз бүрийн мөргөлдөөн дэх талуудын зан үйлийн шалтгааныг задлан шинжилснээр тэд өөрсдийн ашиг сонирхол, эрх ашгийг хангахыг эрмэлзсэнээс уг үзэгдэл үүдэлтэй болохыг олж харахад хэцүү биш байдаг. Гэвч мөргөлдөөний бодит объектоор манипуляци хийх нь сөргөлдөгч нэг талд нь ашигтай, нөгөө талын хувьд байдлыг хүндрүүлдэг явдал бий.

Тийнхүү мөргөлдөөний объект нь маш олон янз, түүний дотор их бага хэмжээгээр ил, далд байж болно. Ер нь “объектгүй” мөргөлдөөн гэж байдаггүй. Түүгээр ч барахгүй тохиолдлоор явж байсан хүн анхааруулга өгсний төлөө танхай этгээд түүнд халдсан тухай ном зохиолд тэмдэглэсэн жишээг авч үзэж болно. Бидний үзэж байгаагаар мөргөлдөөн, түүний объектын мөн чанарыг ойлгох асуудал гудамжинд явж байсан тохиолдлын хүн танхай этгээдэд анхааруулга өгөх үед биш, харин ямар ч шалтгаангүйгээр бусдад халдаж буй танхайрагчийн үйлдлийг авч үзэх үед үүснэ. Энд бусдад халдаж, тэдэнтэй үзэлцэж байж хангагддаг бодгалын *дотоод араниин, субъектив сэдлээс* мөргөлдөөн үүдэлтэй болохыг ярьж байна. Тухайн тохиолдолд мөргөлдөөний зорилго, эсвэл түүний объект болмоор зүйл нь *халдлагаас үүссэн тугиуур бухимдалтай байдлыг сулруулах* явдал юм. Өөрөөр хэлбэл энд мөргөлдөөн нь түүнд оролцогчдын хувьд “уур хилэнгээ гаргах”, “цэнэгээ сулруулах” нэг арга болжээ.

Мөргөлдөөнд оролцогч талуудын нэг нь түүнийг үүсэхэд ямар ч холбогдолгүй байлаа ч мөргөлдөөнд объект байдаг ба тэр нь далд байж болно. Субъект нь өөрийн зорилго, ашиг сонирхлоо хэрэгжүүлж эхлэх болон хэрэгжүүлэх явцад тодорхой учир шалтгааны улмаас мөргөлдөөн ихэвчлэн үүсдэг. Түүнээс гадна чухамхүү мөргөлдөөн нь өөрөө зорилгодоо хүрэх хэрэгсэл болох нь бий. Мөргөлдөөн бас “*өөртөө зорилго ба агуулгыг*” тээж байдаг гэж Жорж Зиммел (*George Simmel*) анх удаа дуугарсныг онцлон тэмдэглэх хэрэгтэй.¹

Судлаачид мөргөлдөөнд оролцогчдын хүрэнээс гадна орших объектод хүрэх явцад үүссэн бодит мөргөлдөөнийг ихэвчлэн судалдаг нь мэдээж. Өөр нэг төрлийн мөргөлдөөн бий, тэр нь бодит бус мөргөлдөөн юм. Түүний объект нь тэрхүү мөргөлдөөний субьектын салшгүй хэсэг байж, түүнтэй давхацдаг. Зөвхөн өөрийгөө илэрхийлэх боломж хайсан түрэмгий үйлдлээс мөргөлдөөн үүсэх тохиолдол байдаг байна. Энд мөргөлдөөн аливаа бодит үр дүнд хүрэхийн тулд биш, харин түрэмгий зан чанарынх нь дэлбэрэлт болж үүсдэг. Тодорхой бодит үр дүнд хүрэх явцад үүсдэг, мөргөлдөөнд оролцогчдод бодит зорилго байгааг илтгэх бодит мөргөлдөөнөөс ялгаатай нь *бодит бус мөргөлдөөн сөргөлдөгч талуудын туйлын зорилгоос бии харин сөргөлдөгчдийн аль нэгийнх нь, эсхүл хоёулангийнх нь бухимдлыг тайлах иаардлагаас үүдэлтэй. Энэ тохиолдолд мөргөлдөөн аливаа үр дүнд хүрэхэд чиглэгдэхгүй. Яагаад гэвэл бодит бус мөргөлдөөний дотоод зорилго нь зөвхөн бухимдлаа тайлах ба сонгосон сөргөлдөгч талаа өөр “тохирох” объектоор солих явдал юм.*²

Бодит бус мөргөлдөөн нь тийм ч тогтвортой биш. Субьектын бухимдал тайлагдангуут ийм мөргөлдөөн ихэвчлэн төгсгөл болдог. Жишээлбэл, хөл бөмбөгийн улаан фен буюу дэмжигчдийн хувьд өөрсдийнх нь шүтэж дэмждэг баг нь хожигдсоны дараа эсрэг багийн дэмжигчидтэй ч юм уу хэв журам сахиулагч цагдаатай ч юм уу, ер нь хэнтэй зодолдох нь огт хамаагүй хэрэг. Тэдний хувьд эсрэг тал хэн байх нь чухал биш, сэтгэлийн сөрөг хөөрлөө л дарах нь чухал. Гэвч энэ мөч өнгөрмөгц мөргөлдөөн дуусгавар болно.

Тийнхүү мөргөлдөөн бүрт хүмүүсийн үнэн бодитой юм уу хуурамч эрх ашиг, хэрэгцээ хэрэглээ болдог юм бүхэн мөргөлдөөнт харилцааны объект болоод байж л байдаг. Хүмүүний хооронд туйлын олон янзын шалтгаанаар мөргөлдөөн үүсдэг. Мөргөлдөөний шалтгаан нь чухал зүйл ч байж болно, шалихгүй жижиг зүйл ч байж болно. Хамгийн “эмзэг” газрыг байнга хөндсөн сэтгэл санааны жижиг шарх ч мөргөлдөөний үндэс болно. Нөгөө хүнд байхгүй нягт нямбай, нарийн тооцоо бүхий хувийн шинж чанар хүртэл ийм эмзэг зүйлийн нэг байж болдог.

Сэтгэл санаа муу байх, хамт ажилладаг хүндээ дургүй байх нь тодорхой объектгүй мөргөлдөөний шалтгаан болно гэж зарим нэг судлаачид үздэг. Гэвч иймэрхүү үзлийг няцаахад тийм ч хэцүү биш. Дээрх тохиолдолд ч гэсэн сайнгүй байгаа санаа сэтгэлээ тайвшруулах, хамтран ажиллагчдаа дургүйгээ илэрхийлэх “хэрэгцээ” байгаа учраас мөргөлдөөнт харилцаа руу түлхэж байна. Энд мөргөлдөөний объект нь субьектын бухимдлаа тайлах, сөрөг “цэнэгээ сулруулах” хэрэгцээнд оршиж буйг төвөггүй харж болмоор. Нэгэнт хэрэгцээний тухай ярьсных түүний талаар хэдэн үг хэлье.

Хэрэгцээ

Хүмүүст хоол хүнс, хувцас хунар, орон байр, секс гэх мэт физиологийн хэрэгцээ байхаас гадна мөн аюулгүй байдал, маргаашдаа итгэх (орлого олох), хүндэтгүүлэх, дэмжлэг авах, өөрийгөө илэрхийлэх зэрэг нийгмийн шинжтэй хэрэгцээ байх. Амьд организм оршин тогтнох, хөгжихөд хэрэгцээг хангах нь чухал бөгөөд хэрэгцээнээс улбаатай мөргөлдөөн гарах нь түгээмэл байдаг. Сэтгэл зүйн үүднээс бол мөргөлдөөний субьектын хэрэгцээ гэдэг нь тэдний оршин амьдрахад зайлшгүй чухал болж байгаа мөргөлдөөний объект байдлаар илэрч буй тийм байдал юм.

Хэрэгцээ гэдэг нь бие хүн, нийгмийн бүлэг хийгээд нийт нийгмийн амьдрал, үйл ажиллагааг дэмжиж тэтгэхэд зайлшгүй шаардлагатай зүйлээр гачигдах юм уу дутагдахыг хэлнэ. Чухамхүү энэ нь субьектын идэвхжилийг дотроос нь өдөөгч болдог.

1 Simmel. G., Conflict and the Web of Group Affiliation, Glencoe Free Press, 1956. x. 28

2 Coser Lewis, The Functions of Social Conflict, New York, The Free Press. 1956. x. 162

Гэвч хэрэгцээ байх нь шууд мөргөлдөөн үүсэх нөхцөл болохгүй. Хэрэв хэрэгцээгээ хангах явдал нь бусад хүний эрх ашиг, үнэт зүйлс, сэтгэл санааг хөндөхгүй байвал ямар ч мөргөлдөөн үүсэхгүй. Хэрвээ хоол хүнс, ундны ус бүгдэд хангалттай байвал хүмүүс түүний төлөө тэмцэлдэхгүй биз ээ. Түүнчлэн хүн (нийгмийн бүлэг, нийгэм) ямар нэг зүйлээр бодитой гачигдаж байлаа ч хэрэгцээ болж буй тэр зүйлээ ухаарч ойлгохгүй байж болно. Ийм тохиолдолд хэрэгцээ нь бас мөргөлдөөний шалтгаан болдоггүй. Тодруулж хэлбэл ухамсарлагдаагүй хэрэгцээ нь мөргөлдөөний шалтгаан болохгүй. Мөргөлдөөний шалтгаан нь гагцхүү ашиг сонирхол, эрх ашиг болж буй ухамсарлагдсан хэрэгцээ мөн. Хамтран амьдарч, ажиллаж буй хүмүүст хэрэгцээ болж ухамсарлагдсан тэр зүйл дутагдах байдал ажиглагдмагц л мөргөлдөөн үүсдэг байна. Ийм учраас хэрэгцээ бол субъектүүдын идэвх зүтгэлийн хамгийн гүнзгий уг сурвалж болж, тэднийг сөргөлдөөнт үйлдэл хийхэд түлхдэг байна. Ийнхүү хэрэгцээ бол хувь хүний зан үйлийг, тэр дундаа сөргөлдөөнт зан үйлийг зохицуулдаг тийм зүйл юм. Харин хувь хүний ашиг сонирхол, сэдлэг, зорилго, үнэт зүйлсийн баримжаатай холбоо уялдаатайгаар түүнийг зохицуулна.

Хэрэгцээ нь хүмүүний ашиг сонирхлын нэг үндэс болж улмаар ашиг сонирхлын мөргөлдөөнд хүргэх нь бий. Харин ашиг сонирхол гэдэг нь өөрөө бие даасан ойлголт бөгөөд энэ талаар тусгайд нь авч үзсэн байгаа.¹

Эрх мэдэл

Мөргөлдөөний өөр нэг сурвалж нь эрх мэдэл ам. Эрх мэдэл бол нийгмийн систем үүргээ гүйцэтгэхийн чухал нөхцөл болдог байна. Энэ утгаар нь авч үзвэл эрх мэдэл байх, түүнийг албадлагын шинжтэй үр дагавар дасалдах нь нийгмийн харилцаанд зайлшгүй гэсэн үг. Хэнд ч захирагддаггүй, бусдын нөлөөнд автдаггүй, өөрөө бусдад нөлөөлдөггүй дан тийм хүмүүсүүс бүрдсэн нийгэм байж болно гэж төсөөлөхөд бэрх.

Өргөн утгаар нь авч үзвэл эрх мэдэл гэдэг нь үр нөлөөтэй үйлдэл хийх хэрэгсэл, нөлөө үзүүлэх чадамж юм. Гэвч зарим хүмүүс эрх мэдлийг бусдад дарамт шахалт үзүүлэх, бусдыг өөрийн хяналтанд байлгаж, тэднийг өөрийн ашиг тусын тулд ашиглах хэрэгсэл гэж үздэг. Эрх мэдлийн иймэрхүү тодорхойлолт нь бусдын төрх байдлын чиг баримжаа болбол энэ нь зайлшгүй хор хөнөөлтэй мөргөлдөөнд хүргэнэ. Учир нь гэвэл, юун түрүүнд харилцаанд хамаарах талуудын аль нэг нь үнэн хэрэгтэй эрх чөлөөгүй болж, нөгөө талаас хараат байдалд орно.²

МӨРГӨЛДӨӨНИЙ СУБЪЕКТИВ ОЙЛГОЦ БА БИЕ ХҮНИЙ ЭЛЕМЕНТ

Бидний анзаарснаар мөргөлдөөн бол нийгэм – сэтгэл зүйн үзэгдэл юм. Ийм учраас мөргөлдөөний талаар ямарваа дүн шинжилгээ хийхдээ түүний нийгмийн уг сурвалж төдийгүй мөн субъектын сэтгэхүйн учир шалтгааныг харгалзан үзэх хэрэгтэй. Мэдээж тэдгээрийн хооронд нягт холбоо, хамаарал бий гэдгийг мартаж аргагүй.

Мөргөлдөөнт харилцан үйлчлэл нь түүний нийгмийн орчин, нөхцөл зэрэг объектив хүчин зүйлээс хамаараад зогсохгүй тухайн нөхцөл байдалд оролцож буй хүмүүс юм уу бүлэгт бий болдог мөргөлдөөний талаарх субъектив ойлгоцоос мөн хамаарна. Энэхүү субъектив ойлгоц нь хэргийн Үнэн бодит байдал, жинхэнэ нөхцөлд тохирч байх албагүй. Эдгээр ойлгоц нь гурван хэлбэртэй байх агаад сөргөлдөгчдийн зан үйлийн үндэс болдог:

1. Өөрсдийн тухай төсөөлөл,
2. Мөргөлдөөний бусад оролцогчдыг мэдрэх ойлгоц,
3. Мөргөлдөөн өрнөж буй макро, микро гадаад орчны төсөөлөл.

Мэдээж бүхэлдээ эдгээр ойлгоцыг объектив бодит байдал бий болгодог. Гэвч бидний зүрх сэтгэл маань бодит ертөнцийг тусгадаг төдийгүй мөн бидний хүн чанарыг ч илэрхийлдэг. Ийм учраас бидний ойлгоц болон бодит чанарын хоорондох харьцаа маш нарийн төвөгтэй бөгөөд бодит байдалтай хэзээ ч бүрэн гүйцэд тохирдоггүйгээр үл барам, тун ноцтой зөрж болох нь мөргөлдөөний бас нэг шалтгаан юм.

1 Болд.Р., ХҮмҮҮний хувийн ашиг сонирхол, Шинэ Толь, 2006. № 56

2 Болд.Р., ХҮмҮҮний хувийн ашиг сонирхол, Шинэ Толь, 2006. № 56

Мөргөлдөөн хумуусийн толгой тархи, оаун ухаанаар дамжиж явагддаг билээ. Тодруулж хэлбэл мөргөлдөөнд бие хүний зан үйл, сэтгэл зүйн элементүүд оролцож байдаг. Сэтгэл зүйн элемент гэдэгт үндсэндээ бие хүний зан үйлийн болоод сэтгэл зүйн шинж чанар, бие хүний зан авирын онцлог, хумууний дүйцээгүй үнэлэлт ба үнэлэмж, ойлголт, зан үйлийн хэв маяг, ёс зүйн үнэт зүйлс хамаарагдана.¹

Бие хүний төлөв байдлын сэтгэхүйн шинж төрхөөр, өөрөөр хэлбэл тууний үнэт зүйлсийн чиг баримжаа, зорилго, иалтгаан, эрх ашиг, хэрэгцээ иаардлагаар нөхцөлдөн үүссэн. мөргөлдөөн нь өөрийнхөө объектоор хамгийн олон янз байж болно. Энд бүх зүйл чухамдаа бие хүн аль нэг объектод ямар учир утга, ач холбогдол өгч байна вэ, тухайн хун энэ объектыг сонирхож байна уу, угуй ау, энэ нь тууний хувьд хэрэгцээ болж байна уу, угуй ау гэдгээс иалтгаална. Гераклитын “илжиг сүрлийг алтнаас илууд үздэг” гэж хэлсэнтэй адилаар зарим хүмүүс үнэт металлын төлөө үхэлдэж байхад зарим нь үзэл санааны төлөө үхэлддэг. Зарим нь нийгмийн үнэт зүйлсийг бататгахын төлөө, эсвэл хувийн амбицын төлөө тэмцэлдэж байдаг.

Бие хумуусийн хоорондын утга санаа, учир холбогдлын энэ зөрүүтэй байдал нь мөргөлдөөний нэг иалтгаан мөн бөгөөд улмаар мөргөлдөөн дэх төлөв байдлын чиг цугам, тууний стратеги, тактишийг тодорхойлдог.

Бие хүний зан авирын төрх байдал, хэв шинж

Мөргөлдөөний өөр нэг багагүй чухал иалтгаан бол бодгалуудын зан авирын ялгаатай байдал байж болно. Хүмүүс зан авираараа таарч тохироогүйгээс болоод зөвхөн гэр булийн мөргөлдөөн гардаг төдийгүй бусад хүрээний мөргөлдөөн ч үүнд хамаатай. Энэ нь хүний үйл ажиллагааны хамгийн олон янзын хүрээн дэх нэн их дэлгэрсэн иалтгаан мөн.

Зан авирын илрэл, өөрөөр хэлбэл бие хүний зарим шинж чанар хэтэрхий тод илрэх явдал нь мөргөлдөөн үүсэхэд багагүй нөлөөтэй. Яагаад гэвэл зан авирын “түгээмэл биш” шинж чанар байх бөгөөд тэдгээрийн зарим нь нилээд сөргөлдөх чиг хандлагатай байдаг. Жишээ нь дэндүү хардамтгай байдал, өөрийгөө хэтэрхий дөвийлгөх, бусдынхаа бодол санааг үл тоох зэрэг зан авиртай хүний уршгаар зөрчил нэн хурцаддаг тал бий.

Тийм хүнийг заримдаа сөргөлдөөнт хувь хун гэж нэрлэх нь буй. Тэд сөргөлдөөнт нөхцөл байдал зохисгүй чиглэлд өрнөх үйл явцыг олон дахин хурдасгадаг өвөрмөц идэвхжүүлэгчийн үүрэг гүйцэтгэдэг байна. Иймд сөргөлдөөнт хувь хүний талаар илүү тодруулах нь зүйтэй болов уу:

1. *Сүржигнэх хэв маягийн сөргөлдөөнт хувь хун. Ийм хүн ямагт олны анхаарлын төвд байхыг хичээнэ. Бусдын нүдэнд сайхан харагдах дуртай. Хүнтэй харилцахдаа уг хүн өөрт нь хэрхэн хандаж байгааг харгалзана. Иймэрхүү хэв шинжийн хүн аар саар шалтгаанаар үүссэн өнгөцхөн мөргөлдөөн дунд өөртөө итгэлтэй байдаг. Гэхдээ өөр маягийн сөргөлдөөнт нөхцөл байдалд ч амархан дасаж зохицно. Сэтгэл хөдлөл давамгайлсан зан үйл зонхилж, ухаалаг хандлага сулхан илэрнэ. Үйл ажиллагаагаа алдаг оног төлөвлөж, төлөвлөснөө биелүүлэх нь муухан байна. Чимхлүүр нарийн, системтэй ажлаас зайлсхийнэ. Мөргөлдөөнөөс зайлсхийхгүй, харин маргаантай нөхцөл байдалд барьц алдах нь бага. Өөрөө маргааны эх сурвалж болох нь олонтаа байвч түүнийгээ мэддэггүй.*

2. *Холбирхой хэв маягийн сөргөлдөөнт хувь хун. Энэ бол өөртөө хяналт тавих талаар хангалтгүй цочмог хүн болой. Ийм хүний зан байдлыг урьдаас мэдэхэд хэцүү. Олонхидоо өдөж хатгасан түрэмгий авир араншинтай байна. Омог нь хөдлөхөөрөө хамт олны нийтээр хүлээж авсан зан үйлийг тоож анхаардаггүй. Өөрийгөө дөвийлгөж үнэлэх хандлагатай. Өөрийгөө чухал хүн гэж нотолж байхыг үргэлж шаарддаг. Амжилт бүтэлгүй олон явдлын бурууг бусад руу түлхэх гэдэг. Өөрийн үйл ажиллагааг зөв төлөвлөх юм уу төлөвлөснөө тууштай биелүүлж чаддаггүй. Өөрийн үйл хөдлөлийг хэсэг бүлгийн зорилго юм уу тодорхой нөхцөл байдалтай уялдуулах чадвар муу хөгжсөн. Урьдын туршлагаас сургамж авах нь бага.*

1 Bold.R., Konflikty Spoleczne w Przedsiębiorstwie Przemysłowym, Praca magisterska, Akademia Ekonomiczna w Poznaniu, 1980. x. 45-47

3. *Чиглэсэн зорилготой сөргөлдөөнт хувь хүн.* Ийм хүн мөргөлдөөнийг өөрийн хувийн зорилгод хүрэх арга хэрэгсэл гэж үздэг. Мөргөлдөөн дэгдээхдээ тун ч гарамгай этгээд. Хүмүүсийн хоорондын харилцаанд арга мэх, сэтгэл зүйн тоглоом хэрэглэх хандлагатай. Сөргөлдөөнт нөхцөл байдалд ухаалаг хөдөлж мөргөдөөн өрнөх янз бүрийн хувилбарыг тооцоолон, оролцогч талуудын байр суурийн хүчтэй ба сул талыг эрүүл саруулаар үнэлэх чадвартай. Мөргөлдөөний үед хүнтэй харилцах сайтар боловсруулсан арга техникийг эзэмшсэн байна. Сөргөлдөөнт хувь хүний хамгийн аюултай хэв шинж гэж үзэж болно.

Түүнчлэн тодорхой ажил мэргэжлийн хүмүүсийн хэт ялгаатай байдал, бодит байдлыг янз бүрээр хүлээн авч, юмс үзэгдлийг эрс тэс үнэлж цэгнэдгээс шалтгаалан зөрчил, мөргөлдөөн бас үүсч болно. Жишээлбэл, яруу найрагч, судлаач хоёрын асуудалд хандах ялгаа. “Яруу найрагч” бол илүү тэнгэрлэг бөгөөд түүнд уянгын аястай дүрслэн сэтгэх, бодит байдалд сэтгэлийн хөөрлөөр хандах шинж давамгай байдаг. Харин “судлаач” бол асуудалд илүү бодитой ханддаг, яриа хэлэлцээ, судалгаа шинжилгээний үеийн сэтгэлийн хөөрлийг зөвхөн ажил хэрэгт саад болдог гэж үздэг. “Судлаач” нь ямарваа асуудлыг хэлэлцэх үедээ баримт, нотолгоо, учир шалтгааныг шаарддаг бол “яруу найрагч”-ийн хувьд уран яруу, сэтгэл догдлуулсан яриа хөөрөө байхад хангалттай аж.

Тийм болохоор мөргөлдөөн гэдгийг мөргөлдөөний субъектүүдын сөрөг ажиллагаатай холбоотой, тэднийг нэг нэгнийхээ талаарх сөрөг сэтгэлийн хөөрлөөр дагалддаг, нийгмийн харилцан ажиллагааны үйл явцад үүсдэг зөрчлийг өрнүүлж дуусгах хамгийн хурц арга гэж ойлгоно. Мөргөлдөөний субъектүүдын сөрөг ажиллагаа нь харилцаа, зан төлөв, үйл ажиллагаа гэсэн гурван хүрээнд явагдаж болно. Сөрөг ажиллагаа нь дургүйцлээ илэрхийлэх, эсрэг этгээдийн үйлдэлд саад хийх, түүнд материаллаг болон сэтгэл санааны хохирол учруулах зорилгоор харилцах буюу үйл ажиллагаа явуулахад оршино.

Ойлголт, дүйцээгүй үнэлэлт, үнэлэмж

Мөргөлдөөн хэмээх үзэгдэл нь хүмүүний зөв, эсхүл буруу ойлголтын шууд үр дүн юм. Хүмүүс нэг зүйлийн талаар өөр өөр ойлголттой байх явдал бий. Яг л Т.Гоббсын хэлсэнтэй адилаар “нэг хүн нь айдас гэж нэрлэж буйг нөгөө хүн нь цэцэн мэргэн бодол гэж нэрлэдэг, нэг нь шударга ёс гэж үзэж байхад нөгөө нь харгис хэрцгий гэж үздэг, нэг нь өгөөмөр сэтгэл гэж буйг нөгөө нь үрэлгэн зан гэдэг, нэг нь мунхаглал гэж буйг нөгөө нь хашир зан гэж нэрлэдэг” ажээ. Эдгээр өөр хоорондоо ялгаатай ойлголт нь үнэн хэрэгтээ буруу ойлголт байж болно. Гэвч энэхүү буруу ойлголтыг тухайн төсөөлж буй этгээд үнэн зөв гэж үзвэл, энэ нь уг хүндээ “үнэн” болдог байна. Түүнчлэн хүмүүс дор бүрнээ чухамхүү өөрсдийн санаа бодол нь үнэн зөв гэдгийг батлах хангалттай баримт, шалтгааныг байнга олдог ажээ.

Бид нэг төрлийн юмс, үзэгдлийн талаарх хүмүүсийн өөр өөр ойлголтыг бүрэн халж зөвхөн бодит байдалтай нийцэх ёстой гэж хэлж чадаж байвал сайн хэрэг. Гэхдээ энэ нь хамгийн үл гүйцэлдэх (утопи) зүйл байх. Учир нь бодит байдал нь өгөгдсөн дурын нэг оюун ухаанаар танин мэдэхэд дэндүү нарийн төвөгтэй зүйл байж магадгүй.

Мөргөлдөөн үүсч даамжрахад дүйцээгүй төсөөлөл, үнэлэлт, өөрийн үнэлэмж томоохон үүрэг гүйцэтгэнэ. Нийгмийн харилцааны үнэлгээний шинж чанарыг олон үеийн сэтгэгч нар ажигласан байдаг. Хүний аливаа үйлдлийг нийгмийн үнэт зүйлсийн хам цогцоос гадна, дангаар нь аваад үзвэл саармаг шинжтэй байдаг аж. “Үйлдэл нь гэмт хэрэг учраас олны ухамсрыг зэвүүцүүлнэ гэж ярих нь зохисгүй, харин уг үйлдэл нь олны ухамсрыг зэвүүцүүлж байгаа учраас гэмт хэрэг болж байгаа юм. Бид тухайн үйлдлийг гэмт хэрэг болохоор нь буруушааж байгаа юм биш, тэрхүү үйлдлийг бид буруушааж байгаа болохоор уг үйлдэл нь гэмт хэрэг болж байгаа юм” хэмээн алдарт Эмиль Дюрхайм (*Emil Durkheim*) тэмдэглэжээ.¹

Үзэгдэл буюу үйлдлийн үнэлэлт нь тэдгээрийн ямар нэг “бодит” чанараас гарч байгаа юм биш, харин бидний, тэдгээр үзэгдэлд юмуу үйлдэлд хандах субъектив харилцаанаас урган гардаг болохыг сайх иш татсан үг баталж байна. Субъектын аливаа үйлдэл нь гагцхүү тухайн нийгэмд ноёрхож буй

¹ Дюркгейм. Э., О разделении общественного труда, Москва, 1992. х. 82

үнэт зүйлс, үнэлэмжийн системээс хамаарч нэг бол эерэг, аль эсхүл сөрөг болж ирдэг байна. Харин үнэлэмж гэдэг нь доктор Г.Чулуунбаатарын үзэж буйгаар "...байгаль, нийгэм, хүний амьдралын үй түмэн үзэгдэлд сэтгэн үйлдэгч тодорхой субъектын зүгээс хандаж буй хандлага, үзэл бодол, үйл ажиллагааны нийлбэр цогцыг" хэлнэ.¹

Нэмж хэлэхэд үнэт зүйлс, зарчмын талаар сөргөлдөж байна гэж итгэснээр хүмүүс өөрийн итгэл үнэмшлийг хамгаалах, өөрийн хүссэний төлөө өөрөө зөв гэж итгэн улайран зүтгэх үндэслэл болдог. Үнэн хэрэгтээ мөргөлдөөн нь материаллаг бус үнэт зүйлс, зарчмуудтай огт хамаагүй, тэдгээрийг зөвхөн эрхэмлэн дээдлэхтэй холбоотой ажгуу. Өөрөөр хэлбэл энэ тохиолдолд хүний итгэл үнэмшлийн асуудал яригдаж байна.

Ийм мөргөлдөөн нь эд баялаг, эрх мэдлээс улбаатай ашиг сонирхлын мөргөлдөөнөөс ялгаатай байдаг. Ашиг сонирхлын мөргөлдөөний тухайд бол сөргөлдөгч талууд асуудал чухам юу болох, юуг алдах, юуг олохын тулд зогсож буйгаа гол төлөв тодорхой ойлгож байдаг. Харин итгэл үнэмшил бол хүмүүний бодол санааг чимээгүй бүрдүүлэгч мөн. Хүмүүс нийгэм, улс төр, шашин, ёс суртахууны талаарх итгэл үнэмшлийнхээ төлөө өөрсдийгөө золиослоход бэлэн байдаг явдал бий. Итгэл Үнэмшил эвлэршгүй зөрчилдөх үед нийгэм тэр аяараа хуваагдаж болно. Ашиг сонирхлын мөргөлдөөн харьцангуй богино хугацаанд үргэлжилдэг бол итгэл үнэмшлийн холбогдолтой мөргөлдөөн түүхэн хугацаанд ноёрхдог юм.

Мөргөлдөөний хамгийн чухал хүчин зүйлсийн талаарх хэлэлцүүлгээ түүний нэгэн төрөл болох бие хүний сэтгэл зүйн дотоод зөрчилдөөнд анхаарал хандуулалгүй үлдээж болохгүй биз ээ. Дашрамд тэмдэглэхэд бие хүний сэтгэл зүйд явагдаж буй эсрэг тэсрэг, хоорондоо үл таарах бодол санаа, хүсэл эрмэлзлэлийн тухайд мөргөлдөөн гэдэг үгийн оронд "зөрчилдөөн" гэх нэр томъёог хэрэглэж хэвших нь илүү тохиромжтой юм.

Бие хүний сэтгэл зүйн дотоод зөрчилдөөн бол хүмүүний сэтгэлийн дотоод ертөнцийн бүтцийн сунжирсан тэмцлээр үүдэн гарсан, нийгмийн орчинтой зөрчилтэй хэлхээ холбоог илэрхийлдэг, шийдвэр гаргахыг саатуулж буй сөрөг сэтгэлийн шаналал юм.²

Бие хүний аливаа дотоод зөрчилдөөний үндэс нь сонголтын асуудал болой. Харилцан бие биенээ үгүйсгэсэн хүсэл тэмүүлэл нь дилемм (хоёроос нэгийг нь сонгох) бие хүний дотоод зөрчилдөөнийг төрүүлдэг. Өөрөөр хэлбэл бие хүний дотоод зөрчилдөөн нь ямагт бие хүний ухамсар дахь эсрэг тэсрэг хоёр хандлагын тэмцэл байдаг. Үүнийг амтат бялуугаа идэх ч хэцүү, хадгалах ч бүр хэцүү байдалтай байгаа хүүхдийн сэтгэл зүйтэй зүйрлэж болно.

Нийгмийн мөрсөлдөөн нь бие хүний сэтгэл зүйн дотоод зөрчилдөөнтэй нягт холбоотой. Ийм учраас хүмүүний сэтгэхүүд явагдаж буй зөрчилдөөнтэй үйл явцыг судлахгүйгээр нийгмийн мөргөлдөөний учир шалтгааныг ойлгоход бэрхшээлтэй. Бие хүний дотоод зөрчилдөөн нь бусад аливаа мөрсөлдөөний нэгэн адил "хоосон газар"-т үүсдэггүй. Тэр нь нийгэм, байгууллага, бүлэг дэх бие хүний статусаар үүсдэг гадаад шалтгаантай. Эдгээр шалтгаан нь өөрөө нийгмийн макросистемийн түвшинд үүсч, нийгмийн байгуулал, түүний улс төрийн тогтолцоо болон эдийн засгийн амьдрал дахь зөрчлүүдтэй холбоотой байдаг. Хүн өөрөө нийгмийн хэсэг болохын хувьд түүний ухамсар, сэтгэл зүйн дотоод ертөнцийн учир шалтгаан болдог нийгмийн мөргөлдөөнт харилцааны бүхэл бүтэн системээс "мултран гарч" чаддаггүй юм.³

Ийнхүү мөргөлдөөнийг ойлгох тулгын гурван чулууны бүтэц, үндсэн шинжийг тодруулснаар Та бид одоо "мөргөлдөөн" хэмээх ойлголтын тодорхойлолтыг авч үзэхэд бэлэн боллоо.

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ

"Мөргөлдөөн" хэмээх ойлголтыг тодорхойлоход түүнээс илүү өргөн категори болох зөрчил рүү хэлбийх хандлагатай байдаг. Гэвч тодорхойлох тийм арга нь мөргөлдөөнт харилцааны өвөрмөц байдлыг хэрэгсэхгүй байх уршиг дагуулдаг. Тиймээс бидний үзэж байгаагаар тусгайг ерөнхийд хамааруулах тийм хандлага нь хангалтгүй бөгөөд заримдаа алдаанд ч хүргэж болно.

1 Чулуунбаатар.Г., Нийгмийн ардчилсан үнэлэмжийн тогтолцоо, Шинэ толь, № 23, УТБА, 1998, х. 16

2 Bold. R., Konflikty Spoleczne w Przesiebiorstwie Przemyslowym, Praca magisterska, Akademia Ekonomiczna w Poznaniu, 1980. x. 31

3 Болд.Р., Хүмүүний хувийн ашиг сонирхол, Шинэ Толь, 2006. № 56

Зөрчил, мөргөлдөөн хоёрын хооронд нягт холбоо байдаг ч гэсэн тэдгээрийг шинжлэх ухааны түвшинд ижил утгатай ойлголт мэт үзэх үндэслэлгүй ба нэг нэгнийнх нь эсрэг сөргүүлэн тавьж бас болохгүй. Зөрчил, эсрэг тэсрэг байдал, ялгаа бол мөргөлдөөн үүсэж өрнөхөд зайлшгүй боловч хангалттай нөхцөл болдоггүй.

Орчин үеийн социологийн бүтээлд зөрчил ба мөргөлдөөний хоорондын холбооны тухай асуудлыг Английн нэрт социологич Антони Гидденс (*Antoni Giddens*) авч үзсэн байна. “Мөргөлдөөн нь миний бодлоор, тэмцлийн үүсэл, гарал ямар байх, түүний арга, талууд тус бүрийн дайчилж буй хэрэгсэл юу болох зэргээс үл хамааран үйл ажиллагаа явуулж буй хүмүүс, бүлэг хоорондын бодит тэмцэл юм. Зөрчил гэдэг ойлголт зарим бүтцэд хамаардгаараа мөргөлдөөнөөс ялгаатай. Зөрчил нь нийгмийн системийн бүтэц дэх эмзэг тал, сул хэсгийг илэрхийлдэг учраас энэ хоёр ойлголт хоорондоо нэн ойр юм. Түүний зэрэгцээ зөрчил янз бүрийн бүлэг, төрөл бүрийн хүмүүс хоорондын, түүний дотор ангиуд хоорондын ашиг сонирхлын ялгааг заадаг” гэж тэрбээр бичжээ.¹

Философид, харилцан бие биенээ үгүйсгэхийн хэрээр нөхцөлдүүлж байдаг эсрэг тэсрэг талуудын хоорондын харилцааг зөрчил гэдэг. Харин социологийн утгаар бол зөрчил гэдгийг нийгмийн нийтлэг, бие хүн, бүлгийн материаллаг болон материаллаг бус үнэт зүйлс, ашиг сонирхол, зан үйл хоорондоо эсрэг тэсрэг байдалтай байхыг хэлнэ. Зөрчил өөрөө заавал мөргөлдөөн болж хувирах албагүй. Тэр тусмаа ухамсарлагдаагүй зөрчил мөргөлдөөн болтлоо нилээд зай бий. Энд онцлон хэлэхэд ухамсар нь зөрчил, мөргөлдөөнгүйгээр оршиж чадах боловч харин зөрчил нь ухамсарлагдаагүйгээр үйл явц болж өрнөх боломжгүй юм. Эсрэг тэсрэг байдал болон зөрчлийг агуулагчид, эсвэл дор хаяж аль нэг тал нь ухамсартайгаар сөрөг үйлдэл хийж эхлэх үед тэдгээр нь мөргөлдөөнд шилждэг болой. Товчхон хэлбэл мөргөлдөөн нь ухамсарлагдсан тодорхой объектив, эсвэл субъектив зөрчлийн илрэл мөн.² Субъектив зөрчил гэдэг нь хийсвэр, санаандаа ургуулсан зөрчил юм.

Мөргөлдөөн үүсэн хөгжихөд нийгэмд оршиж байгаа бодит зөрчил онцгой учир холбогдолтой нь маргаангүй юм. Чухам тэдгээр зөрчил нь цаашдаа мөргөлдөөний агуулгыг тодорхойлдог болно. Гэхдээ л энэ байдлыг хөдөлбөргүй тогтсон тодорхой стандарт мэтээр хандаж болохгүй. Бодит зөрчил нь тодорхой тохиолдол, өвөрмөц нөхцөлд биелэлээ олдог. Зөрчил бүхэн зөрчлийн бүх системд өвөрмөц байдлаар илрэх бөгөөд зохих ёсоор шийдвэрлэхийг шаарддаг. Жишээлбэл, эдийн засгийн салбар дахь тодорхой зөрчлийг шийдвэрлэх түлхүүр нь эдийн засгийн бус, харин улс төрийн, эсвэл үзэл суртлын хүрээнд байж болох бөгөөд мөн эсрэгээр ч байж болно.

Үндэсний философичдын үзлээр бол зөрчил нь бодит байдлын янз бүрийн хүрээнд өөр өөрөөр өвөрмөц байдлаар илрэх авч, тэр бүхэнд нийтлэг, түгээмэл тогтолцоо, учир шалтгаан, зүй тогтол бий.³

Мөргөлдөөний үндэс болж байгаа зөрчлийг зөв ялгах нь мөргөлдөөний хэлбэр маягийг тодорхойлоход дөхөм болдог. Антагонист (үл эвлэрэх) зөрчил антагонист мөргөлдөөнд хүргэдэг бол агонист зөрчил агонист (эвлэрэх, зохицох) мөргөлдөөнд хүргэнэ. Зөрчлийн ялгааны зэрэгт Үндэслэсэн мөргөлдөөний ангилал нь арай өөрөөр буюу “тоглоомын онолоор” тайлбарлагддаг юм. Үүнд а) тэг нийлбэртэй мөргөлдөөн, б) тэг бус нийлбэртэй мөргөлдөөн гэх мэт. Зөрчлийн хэв маягийн ялгаанууд нь мөргөлдөөний мөн чанарыг ойлгоход чухал ач холбогдолтой, учир нь ихэнх тохиолдолд мөргөлдөөний хөгжил тодорхой хэмжээгээр түүний үндэс болж буй ерөнхий бодит зөрчлийг тусгадаг. Тийнхүү мөргөлдөөн бол зөрчлийг шийдвэрлэх хамгийн түгээмэл арга хэрэгсэл мөн.

СӨРГӨЛДӨӨНТ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нийгэм, улс төрийн амьдралын субъектүүдийн хооронд мөргөлдөөний объект байгаа нь мөргөлдөөн үүслээ гэсэн үг хараахан биш. Мөргөлдөөн бол нэгдүгээрт, зөрчил үүсэж хөгжихтэй,

1 Krzykala. F., Socjologia pracy, Poznan. 1978. x. 146

2 Bold. R., Konflikty Społeczne w Przedsiębiorstwie Przemysłowym, Praca magisterska, Akademia Ekonomiczna w Poznaniu, 1980. x. 35

3 Хавх. Н., Монголчуудын нҮҮдлийн соёл иргэншлийн гҮн ухаан, УБ. 2005. x. 26-38

хоёрдугаарт, тийм зөрчил бий болсон болон түүнийг шийдвэрлэх зайлшгүй шаардлагатайг субъектүүд ухамсарлахтай холбогдсон сөргөлдөөнт нөхцөл байдалтай уялдан үүсдэг болой.

Хэрэв субъект зөрчлийг ухамсарласан хэдий ч үүний улмаас бий болсон сөрөг сэтгэлийн хөөрөл, бачимдал бухимдлаа гадагшаа илэрхийлэхгүй дотроо барьсан (хадгалсан), нөгөө талынхаа эсрэг мэдэгдэм, тодорхой үйлдэл хийгээгүй байгаа тийм нөхцөл байдлыг мөргөлдөөний өмнөх үе буюу сөргөлдөөнт нөхцөл байдал гэнэ. Энд сөрөг сэтгэлийн хөөрөл гэдэгт субъект эсрэг этгээдийнхээ талаар таагүй сэтгэгдэлтэй буюу түүнд дургүйцсэн, эсхүл дайсагнасан байдалтай байхыг ойлгомой.

Мөргөлдөөний өмнөх үед сөргөлдөгч талууд давшингүй ажиллагаа явуулах эсэхээ шийдэх, энэ талаарх өөрсдийн нөөц бололцоог үнэлж цэгнэдэг байна. Ийм нөөц бололцоонд материаллаг үнэт зүйлс, мэдээлэл, эрх мэдэл, нэр хүнд гэх мэт зүйлүүд багтана.

Хүмүүсийн үзэл бодлын ялгаа, эсрэг тэсрэг байр суурь, аливаа үйл явдлыг хүлээн авч үнэлэх зөрүү нь ихэвчлэн сөргөлдөөнт нөхцөл байдалд хүргэдэг. Жишээлбэл: Бараа, үйлчилгээний Үнэ тарифийг нэмэгдүүлэх шийдвэр нь өөрөө сөргөлдөөнт нөхцөл байдлыг бий болгодог. Үнэ хөлс өсөхөд баярлаж хүлээж авдаг хэрэглэгч гэж бараг байдаггүй, бүгд л ямар нэгэн хэмжээгээр бухимдалд ордог. Ялангуяа нэн өргөн хэрэглээтэй талх, мах, бензин шатахууны үнийг нэмэх шийдвэр ард иргэдийн уур хилэнг бадрааж улмаар ноцтой мөргөлдөөнд хүргэсэн тохиолдол олон байдаг. Үүний нэг жишээ нь 2005 оны сүүлчээр Улаанбаатар хотод автобусаар зорчих хөлсийг хоёр дахин нэмэх шийдвэр гаргаснаас болж олон хүнийг хамарсан тэмцэл өрнөж, эцэстээ шийдвэрийг цуцлуулснаар мөргөлдөөн намжсан билээ.

Түүнчлэн орон тооны цомхотголын өмнө аттестатчилал явуулах, шагнал урамшилд тодорхойлох, сонгууль зарлах зэрэг нь мөн л сөргөлдөөнт нөхцөл байдал үүсгэж болно. Ердийн гэр бүлийн хүрээнд гэхэд л, хэрэв хайртай хосуудын нэг нь ажлаа тараад шалтгаангүйгээр оройтож ирвэл хардалт үүсгэж байдал муудах тийшээгээ хандах жишээтэй. Энэ тохиолдолд “хардалт” бол сөргөлдөөнт нөхцөл байдал мөн. Ер нь худал хэлэх, хуурах, хумслах мэт үйлдэл нь сөргөлдөөнт нөхцөл байдал үүсгэх нягууртай.

Ингэхдээ сөргөлдөөнт нөхцөл байдлын талаарх бидний ойлгоц, төсөөлөл ямар ч байлаа гэсэн тэдгээр нь талуудын зохих үйлдэл болж хэрэгжээгүй байхад мөргөлдөөн ямар ч гэсэн эхлэхгүй гэдгийг бодолцох нь зүйтэй юм аа.

Сөргөлдөгч талууд мөргөлдөөнт зан үйлд шилжих нь далд нууц үеэс ил нээлттэй үе рүү шилжиж буйн шинж юм. Дээр дурьдсанчлан мөргөлдөөнт нөхцөл зан үйл нь талуудын гадагш илэрсэн үйлдэл юм. Харилцан үйлчлэлийн онцгой хэлбэрийн хувьд эдгээр үйлдлийн өвөрмөц онцлог нь эсрэг этгээдийг зорилгодоо хүрэхэд нь саад хийж өөрсдийн зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байдагт оршино.

МӨРГӨЛДӨӨНИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Нийгмийн амьдрал дахь зөрчил, мөргөлдөөний асуудал эртнээс уламжлалтай, байнгын чухал шинжтэй боловч шинжлэх ухаан өнөөдрийг хүртэл “мөргөлдөөн” хэмээх ойлголтын нэгдсэн тодорхойлолтыг хараахан гаргаж чадаагүй байна. Тэр ч бүү хэл мөргөлдөөний олон талт байдлыг тодорхойлсон нэгдсэн хандлага огт бүрдээгүй байна. Мөргөлдөөнийг тодорхойлоход түүний өргөн хүрээтэй, өөрчлөмтгий шинж чанар бэрхшээл учруулдаг болой.

Түүнчлэн мөргөлдөөн гэдэг Үгийг чухам шинжлэх ухааны аль салбарт хэрэглэж байгаагаас хамаарч ойлголт өөр өөр байж болно. Тухайлбал түүнийг нийгмийн үйл явцад хэрэглэж байна уу, эсвэл ердийн сэтгэл зүйд үү, аль эсвэл байгалийн үзэгдэлд үү гэдгээс хамаарч өөрөөр тодорхойлох нь мэдээж. Мөргөлдөөн нь амьд байгальд, хүмүүний нийгэмд, түүний дотор улс төрд, мөн бие хүний сэтгэл зүйд байх.

Харин бидний сонирхлыг илүү ихээр татаж буй нийгмийн мөргөлдөөний тухайд бол маш олон янзын тодорхойлолт бий. Марксист уламжлалаар бол нийгмийн мөргөлдөөн нь ашиг сонирхлын зөрчил гэж тодорхойлогдоно.¹

АНУ-д мөргөлдөөн судлалыг эхлүүлсэн хүн гэж үнэлэгддэг эрдэмтэн эмэгтэй Жесси Бернارد (*Jessi Bernard*), социологийн үүднээс үзвэл “Нэг бүлгийн хүссэн зүйлийг нөгөө бүлэг нь дангаар эзэмших тохиолдолд төдийгүй түүнчлэн үнэт зүйлс, зорилго, ашиг сонирхол зэрэг үндсэн зүйл зохицохгүй үед бүлэг хоорондын мөргөлдөөн үүснэ” гэжээ.²

Английн социологич Перси Коэн (*Persi Cohen*) “Бусдын зорилгод тээг тавих замаар өөрийн (бие хүн, бүлгийн) зорилгыг хэрэгжүүлэх тийм тохиолдолд нийгмийн мөргөлдөөн үүсдэг” гэжээ.³

Ер нь нийгмийн мөргөлдөөнт загвар дээр тулгуурласан социологийн онолыг бүтээгч өрнөдийн судлаачид мөргөлдөөн хэмээх ухагдахууныг нийгмийн харилцан үйлчлэлийн (интеракци) нэг төрөл буюу бихевиорал (зан үйлийн) шинжтэй үзэгдэл гэж ойлгож байв. Үүний нэгээхэн жишээ бол нэрт социологич Льюис Коузерын (*Lewis Coser*) өгсөн тодорхойлолт билээ: “Нийгмийн мөргөлдөөн гэдгийг үнэт зүйлс, эрх мэдэл, нийгмийн байр суурь болон бүгдэд үл хүрэлцэх эд баялгийн төлөөх тэмцэл хийгээд уг тэмцэлдээнд сөргөлдөгч талуудын зорилго нь шаардлагатай зүйлсийг олж авах төдийгүй өрсөлдөгчөө саармагжуулах, зайлуулах, устгах явдал мөн гэж тодорхойлж болно.”⁴

Үүнтэй төстэй тодорхойлолтыг Оросын судлаач Е.М.Бабосов өгсөн бөгөөд тэрбээр “Нийгмийн мөргөлдөөн (*conflictus* - мөргөлдөх гэсэн латин үгнээс гаралтай) бол эдийн засаг, нийгэм, улс төр, оюун санааны эрх ашиг, зорилгодоо хүрэх болон ашиг сонирхлоо хэрэгжүүлэхэд нь саад болж буй жинхэнэ юм уу хуурмаг өрсөлдөгчөө саармагжуулах (төвийг сахидаг болгох) юм уу зайлуулахад чиглэсэн бие хүмүүс ба нийгмийн янз бүрийн бүлгүүдийн хоорондын тэмцлийн олон хэлбэрээр илэрдэг нийгмийн зөрчлийн хурцдалын туйлын тохиолдол юм” гэжээ.⁵

Дээрх тодорхойлолт нь Коузерын өгсөн мөргөлдөөний сонгодог тодорхойлолтын адилаар хүчирхийллийн ойлголтыг агуулсан байна. Ердийн ойлголтоор мөргөлдөөн нь алив нэг хэлбэрээр гарч буй хүчирхийллийн жирийн илрэл тул дээрх давхцал гайхмаар ч юм биш.

Мөргөлдөөн бол тэмцэл, өрсөлдөөн мөн гэсэн нилээд өргөн утгатай, бихевиорал шинжтэй тодорхойлолтыг Германы эрдэмтэн Ральф Дарендорф (*Ralf Dahrendorf*) өгсөн байдаг. Гэхдээ Дарендорф мөргөлдөөн нь нийгмийн тодорхой бүтцээс үүссэн буюу түүнд нийгмийн янз бүрийн бүлгүүд, тэдгээрт хамааралтай хүмүүс оролцож буй үед л нийгмийн мөргөлдөөн болно гэжээ.⁶

Польшийн нэрт социологич Ежи Вятр (*Jerzy Wiatr*) мөргөлдөөн гэдэг ойлголтыг тэмцэлдээн гэдэг үгээр илэрхийлсэн аж. Тэрбээр “Тэмцэлдээн гэдэгт нийгмийн амьдралын нэг ижил салбарт хоёроос доошгүй этгээд эсрэг тэсрэг зорилгын төлөө зүтгэж, өмнөө тавьсан зорилгоо гүйцэлдүүлэхэд харилцан саад хийж буй бүх нөхцөл байдлыг ойлгоно” гэсэн байна.⁷

Мөргөлдөөний ерөнхий онолын асуудлаар нэрд гарсан мэргэжилтэн Кеннет Е. Боулдинг (*Kenneth Boulding*) мөргөлдөөний нийтлэг загварыг бий болгож, түүнийг хэлбэрчилсэн аппаратын тусламжтайгаар тодорхой тохиолдол бүрт тохирч байхаар тодорхойлохыг оролджээ. Боулдингийн үзсэнээр бол мөргөлдөөн гэдэг нь ухамсарлагдаж боловсорсон зөрчил, өрсөлдөөнт байдал аж. Тэрбээр мөргөлдөөн бол талууд өөрсдийн ирээдүйд эзлэх байр суурийг зөвшөөрөх боломжгүй гэдгээ ухамсарлаад өөрийн хүсэл зорилгод нийцсэн, гэхдээ нөгөө талаас хүлээн зөвшөөрөх аргагүй байр суурийг олж авахад чиглэсэн тийм өрсөлдөөнт нөхцөл байдал юм гэж тодорхойлсон байна.⁸ Боулдингийн тодорхойлолт нилээд статик шинжтэй аж.

1 Болд. Р., К. Маркс ба мөргөлдөөний онол, Шинэ Толь, № 55, УТБА. 2006. х. 115-126

2 Mucha Janusz, *Konflikt i spoleczenstwo*. Warszawa, 1978. х. 14

3 Cohen. P. S., *Modern Social Theory*, London. 1970. х. 184

4 Coser Lewis, *The Functions of Social Conflict*, New York, The Free Press. 1956. х. 8

5 Бабосов Е.М., *Основы конфликтологии*, Минск, 1997. х. 55

6 Dahrendorf, Ralf, *Class and Class Conflict in Industrial Society*, London, 1972. х. 117-135

7 Wiatr Jerzy, *Spoleczenstwo. Wstep do socjologii systematycznej*, Warszawa. 1965. х. 176

8 Boulding K. E., *Conflict and Defence. A General Theory*. New York, 1962. х. 4-5

Нийгмийн мөргөлдөөн гэдэгт оролцогч талууд нутаг дэвсгэр, эсвэл нөөц ресурсийг булааж авахын тулд сөргөлдөгч бие хүмүүс юм уу бүлгүүдийн өмч, эсвэл соёлд заналхийлж, дайрч давших юм уу хориглон хамгаалах хэлбэртэй байх тийм эсрэг тэсрэг байдал, тэмцлийг ойлгоно гэж Оросын социологич А.В.Дмитриев тэмдэглэсэн байна.¹

Үнэндээ энэ тодорхойлолт нь мөргөлдөөний ажил хэргийн үндсэн учир утгыг илэрхийлсэн боловч мөргөлдөөний бүх шинжийг, тухайлбал сэтгэл зүйн шинжийг тусгаагүй байна. Ийнхүү мөргөлдөөний тодорхойлолтын талаар янз бүрийн хандлага байгаа ч түүний түгээмэл шинж чанарыг онцлон үзэж болно. Тухайлбал:

- Ямар ч тохиолдолд субъектүүдын хооронд зөрчил байх, тэрчлэн ашиг сонирхол, эрх ашиг, үнэт зүйлс, зорилго, үүргийн ялгаа орших,
- Сөргөлдөгч талдаа саад учруулахыг эрмэлзсэн үйл ажиллагаа, тэмцэл явуулах,
- Мөргөлдөөнт харилцааны үндсэн шинж болох нэг нь нөгөөдөө таагүй сэтгэл, зөн мэдрэмжээр хандах. Мөргөлдөөн нь энэ шинжээрээ түүнтэй хэлбэрийн хувьд ойролцоо ч мөн чанарын хувьд өөр үзэгдэл болох уралдаан, өрсөлдөөн, спортын тэмцээн гэх мэт нийгмийн харилцан үйлчлэлээс ялгаатай.

Дээрх эргэцүүлэлтэй уялдуулан бид мөргөлдөөн гэж юуны өмнө нийгмийн мөргөлдөөнийг хэлж байгаа бөгөөд энэ нь эсрэг тэсрэг хандлага, зорилго зорилт, байр суурь, үнэт зүйлс, зээл бодол, үнэлэмж бүхий субъектүүдын харилцан үйлчлэл болно.

Тодруулж хэлбэл мөргөлдөөн гэдэгт хоёр буюу түүнээс дssш бие хүн, эсвэл бүлгүүд бие биедээ тодорхой зорилгод хүрэх болон материаллаг хийгээд материаллаг бус үнэт зүйлс олж авахад нь шууд ба шууд бусаар саад хийх, өрсөлдөгчдөө өөрийн ашиг сонирхлыг хэрэгжүүлэх боломж өгөхгүй байх, эсвэл тэдний үзэл бодол, нийгмийн байр суурийг өөрчлөхөд чиглэсэн сөрөг сэтгэлийн хөөрөл бүхий идэвхтэй үйлдэл, тэмцлийг ойлгоно.

Мөргөлдөөн бол зөрчлөөс үүдсэн тодорхой, мэдэгдэм үйл явц төдийгүй чанарын өөрчлөлт мөн. Тэдгээр нь объектив болон субъектив шалтгаанаар үүсэж болох ба сөргөлдөгч талуудын нийгмийн зан үйл, эсрэгцсэн арга ажиллагаа явуулах хэлбэрээр илэрдэг, эерэг, сөрөг үүрэг, үр нөлөөтэй, үргэлжлэх хугацаа, эрчимжилтийн тодорхой түвшин бүхий үзэгдэл юм.

“Мөргөлдөөн” ба “маргаан”, тэдгээрийн ялгаа

Ихэнх хүмүүс “мөргөлдөөн”, “маргаан” гэдэг ойлголтууд нь хоорондоо адилхан хэмээн боддог. Гэвч мөргөлдөөний асуудлыг судалдаг зарим эрдэмтэд тэдгээрийн хооронд нижгээд ялгаа бий гэж Үздэг.

Америкийн судлаач Жон Бэртон (*John Burton*) эдгээр ойлголтын ялгааг тодруулах гэж оролдсон аж. Тэрбээр цаг хугацаа болон утга агуулгын үүднээс дээрх хоёр ойлголтын ялгааг гаргаж ирсэн байна. Маргаан бол Бэртоны үзэж байгаагаар богино хугацааны санал зөрөлдөөн бөгөөд шийдвэрлэхэд харьцангуй хялбар. Харин гүнзгий уг үндэстэй, шийдвэрлэхэд ярвигтай, харьцангуй урт хугацаанд явагддаг үзэгдлийг мөргөлдөөн хэмээн тодорхойлжээ.

Бэртоны тогтоосон дараагийн нэг ялгаа нь маргаан нь хэлэлцэн тохирч болохуйц ашиг сонирхлын илэрхийлэл гэнэ. Энэ нь хоёр талын ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагыг наанадаж зарим талаар хангахуйц шийдлийг олж болно гэсэн үг. Жишээлбэл, Худалдаачин бараа таваараа ахиу үнээр өгөхийг, харин худалдан авагч хямдхан авахыг хүсч байвч тэд аль алиныхаа санаанд таарсан үнэ ханш дээр тохирч чаддаг. Үүнтэй адил хамтран ажиллагч хүмүүс ажил албан дээрээ ямар даалгаврыг хэн нь хийх талаар санал зөрөлдөж болох юм. Хэлэлцэн тохирсны дараа тэдний аль аль нь хийхийг хүсээгүй ямар нэг зүйлийг хийхэд хүрч болох авч үүний оронд тэд маргааныг шийдвэрлэхийн тулд хийхийг хүсч буй зүйлээ хангалттай авч болно.

Нөгөө талаар урт удаан хугацааны мөргөлдөөн нь гол төлөв хэлэлцэн тохирохын аргагүй асуудлуудаас бүрддэг. Тэдгээрт ёс суртахууны юмуу үнэт зүйлсийн гүнзгий уг үндэстэй ялгаа, эсвэл эрх мэдлийн зөрчил агуулагдаж байдаг. Хүний нэр төр, аюулгүй байдал, статустай холбоотой асуудал ч байна. Тэдгээр асуудлын аль аль нь хэлэлцэн тохирохын аргагүй байдаг. Язгуур үнэт

¹ Дмитриев А.В., Социальный конфликт: Общее и особенное, М. Гардарики, 2002. х. 30-31

зүйлсийн талаар хүмүүс найр тавьдаггүй. Тэд сайхан амьдрах бололцоогоо зүгээр нэг сууж байгаад алдахгүй, бас өөрийн нэр төрийг муутгах юмуу унагахыг хүсэхгүй. Иймэрхүү асуудлаарх гүнзгий үндэстэй мөргөлдөөн нь шийдвэрлэхэд ихээхэн бэрхшээлтэй болж, гол төлөв шатлан өргөжих хандлагатай байдаг гэжээ.

Миний ажигласнаар, маргаан гэдэг нь хүмүүс тодорхой асуудлаар санал зөрснөөс болж хоорондоо дан ганц ам хэлээрээ сөргөлдөхийг хэлнэ. Түүнд махбодын (биеийн хүчний) оролцоо байхгүй. Харин мөргөлдөөний тухайд бол гол онцлог нь түүнд үйлдэл (үйл ажиллагаа)- ны аман ба аман бус хэлбэрүүд цөм оролцдогт оршино. Тодруулж хэлбэл, үг хэлээр дайрч давшлахын сацуу хүчний шинжтэй янз бүрийн арга хэрэгсэл ашиглах, махбодын хүчирхийлэл явуулах зэрэг үйлдэл мөргөлдөөнд илэрдэг ажгуу.

Эцэст нь мөргөлдөөнтэй ойролцоо *тэмцээн*, *өрсөлдөөн* зэрэг үзэгдлийн талаар дурьдах нь зүйтэй. Эдгээр үзэгдэлд зарчмын хувьд талуудын тэмцэл байх нь байна. Гэвч энэ нь *тэмцээн* дайсагнах түвшинд хүртэл хурцаддаггүй, хэрвээ бүр дайсагнал үүссэн ч (жишээлбэл, өрсөлдөөний үед), тэр нь нөгөө талын хууль ёсны зан үйлд саад хийх хоёр талын үйлдлийг дагалдуулдаггүй аж. Бүгд амжилтанд хүрч, ингэснээр эсрэг этгээдээ дийлэхийн тулд “өөрийн талбай дээр” хөдөлдөг. Өрсөлдөгчид хааяа хууль бус арга замыг хэрэглэдэг. Гэхдээ оролцогчдын үйлдэл ерөнхийдөө эерэг шинжтэй байх бөгөөд дор бүрдээ дээд зэргийн амжилтад хүрэхийг хичээх учир эсрэг этгээдээ дарах нь тэдний эцсийн зорилго биш болой. Ийнхүү мөргөлдөөн, тэмцээн хоёр ялгаатай боловч тэмцээн нь мөргөлдөөнд шилжиж болно. Энэ нь өрсөлдөгчид бие биеэ шууд дарамтлахад шилждэг өрсөлдөөнд бас хамаатай.¹

Америкийн социологич Кларк Керр (*Clark Kerr*) мөргөлдөөн нь өрсөлдөөнөөс ялгаатай гэж үзэж байна. Тэрбээр *өрсөлдөөн* бол хоёр, эсвэл түүнээс олон талууд уг өрсөлдөөнд шууд оролцоогүй гуравдагч талаас тодорхой ашиг хонжоо олох зорилготой үйл ажиллагаа юм. Харин мөргөлдөөний тухайд бол талууд эсрэг талаасаа ашиг хайсан үйлдэл хийдэг гэжээ.²

1 Дмитриев А.В., Социальный конфликт: Общее и особенное, М. Гардарики, 2002. х. 34

2 Керр. С., Industrial Conflict and Its Mediation, in American Journal of Sociology, 1954. nr 3, х. 235